

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр


“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтыг үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) дүгнэлт гаргалаа. Энэхүү дүгнэлтэд өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 12.1, 12.3 дугаар зүйлд тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана”, мөн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга”-тай нийцсэн эсэх, Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан шаардлагад нийцтэй эсэхэд голлон анхаарсан болно.

Нэг. Төсвийн бодлого, дунд хугацааны макро эдийн засгийн төлөв байдал

1.1 Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлогын чиглэл нь эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой түвшинд хүрэхгүй хэвээр байна. Эдийн засаг дахь төрийн оролцооны оновчтой түвшин, хэлбэрийг тооцох нь судалгааны чухал сэдэв бөгөөд энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг хамгийн их дэмжих төсвийн зарлагын хэмжээг тооцон гаргах боломжтой. Бидний зүгээс Монгол Улс болон ДНБ-ий хэмжээ, бүтцээрээ түүнтэй ижил төстэй 26 орны 2000-2023 оны өгөгдөлд эконометрик шинжилгээ хийж үзэхэд “төсвийн зарлага ДНБ-ий 27 хувь байх нь өсөлтөд хамгийн их эерэг нөлөөтэй” гэсэн үр дүнд хүрэв (Зураг 1). Өргөн мэдүүлсэн төсөлд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь ирэх гурван жилд 31.9 хувиас 28.6 хувьд хүргэж бууруулахаар тусгасан ч дээрх критик утгаас өндөр хэвээр байна.


Зураг 1. ДНБ-ий хэмжээ ижил төстэй 27 орны төсвийн зарлага болон эдийн засгийн өсөлтийн хамаарал, 2023 оны байдлаар



Албани, Азербайжан, Бангладеш, Боливи, Чили, Гүрж, Гана, Гватемал, Гондурас, Киргизстан, Камбож, Молдав, Хойд Македон, Монгол, Малайз, Намиби, Никарагуа, Пакистан, Перу, Филиппин, Парагвай, Руанда, Эль Сальвадор, Танзани, Уганда, Вьетнам

1.2 Төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах бодлогыг хэвээр үргэлжлүүлэх шаардлагатай. ДХТХМ-д төсвийн зарлагыг 2027 онд 36.5 их наяд, 2028 онд 38.6 их наяд, 2029 онд 40.4 их наяд төгрөг байхаар төлөвлөжээ. Энд тусгагдсанаар 2027 оны төсвийн зарлага нь 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тусгагдсан 2027 оны төсвийн зарлагаас 1.9 их наяд төгрөгөөр буюу 2026 оны батлагдсан төсвийн зарлагаас 10.7 хувиар өссөн байна. Энэ нь 2024 он хүртэл огцом өссөн өсөлттэй харьцуулахад доогуур үзүүлэлт боловч энэхүү өсөлтийг сааруулж чадсан 2025 оны 3.2, 2026 оны 4.5 хувийн өсөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

Зураг 2. Төсвийн орлого, зарлагын өсөлтийн хувь



Эх сурвалж: ТТБЗ (2026)-ийн тооцоолол


Түүхий эдийн үнийн өсөлт, нүүрсний экспортын биет хэмжээний өсөлтөөс нэг удаад бий болсон 2022-2023 оны төсвийн орлогод тулгуурлан төсвийн зарлагыг ихээхэн хэмжээгээр тэлсэн нь түүний дараагийн жилүүдийн төсвийн суурь зардлыг өсгөж, төсөвт ихээхэн ачаалал учруулсан оновчгүй, алдаатай шийдвэр байсан. Төсвийн нийт зарлага 2024 онд өмнөх 2023 оны гүйцэтгэлээс 35.9 хувиар, урсгал зардал 29.7 хувиар, хөрөнгө оруулалтын зардал 53.6 хувиар тус тус огцом нэмэгдсэн.

Үүнийг Монгол Улсын Засгийн газар 2025 оны 6 дугаар сард Монгол Улсын 2025 оны төсөвт тодотгол хийх төслийг боловсруулан, УИХ-д өргөн барьж, улмаар 2025 онд батлагдсан төсвийн зарлагыг 1.9 их наяд төгрөгөөр бууруулсан, 2026 оны төсвийн төсөлд зарлагын өсөлтийг 4.5 хувьд хадгалсан нь хэт тэлсэн өмнөх алдааг засахад чиглэсэн гарцаагүй авах шаардлагатай байсан зөв зүйтэй арга хэмжээ болсон гэж ТТБЗ үзэж байна. Иймд төсвийн зарлагын өсөлтийг цаашид хэт тэлэхгүй байх орлогын өсөлтөөс давсан зарлагын өсөлтийг бий болгохгүй байхыг анхаарах хэрэгтэй.

1.3 Дунд хугацаанд инфляцын эрсдэл өндөр байна. 2025 онд Ойрх Дорнодод гарсан мөргөлдөөний нөлөөгөөр нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол, үнийн өсөлт нь дэлхий нийтийг түгшээж байна. Нөхцөл байдал 2026 онд намжин, зах зээл 2027 онд хэвийн төлөвт орно гэсэн таамагт үндэслэн энэ удаагийн ДХТХМ-ийн төсөөллийг боловсруулсан байна. Газрын тос болон бусад өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импортын үнийн өсөлтөөр өдөөгдөн 2026 оны 2-р хагаст инфляц өсөх, улмаар энэ өсөлт 2027 оны 1-р хагаст үргэлжлэх өндөр магадлалтай байна. Нөгөө талаас ДХТХМ-ийн

төсөлд тусгагдсан төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 28.6-31.9 хувь байгаа нь Колин Кларкийн критик хязгаарыг давсан хэвээр байна¹.

Зураг 3. Монгол Улсын төсвийн зарлага, инфляцын хамаарал



Төсвийн зарлага ба инфляцын хувьд 2000-2024 онд дундаж инфляц 8.8, ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь дунджаар 34, урсгал зардлын эзлэх хувь дунджаар 25 хувь байжээ.

1.4 Макро эдийн засгийн ихэнх үзүүлэлтийн таамаглал нь 2027 оны хувьд ТТБЗ-ийн суурь таамаглалтай ойролцоо байна.

Хүснэгт 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны ТХМ-д тусгагдсан зарим үзүүлэлтийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	УИХ-д өргөн барьсан 2027 оны ТХМ /2026.05.01/	ТТБЗ-ийн боловсруулсан таамаглал /2026.03.13/	ОУВС, April 2026 World Economic Outlook /2026.04 cap/	Дэлхийн банк, Mongolia Economic Update, April 2026 /2026.04 cap/
Эдийн засгийн өсөлт, хувь	5.8	5.5-5.6	5.2	5.5
Нэрлэсэн ДНБ /их наяд төг./	114.230	111.4-112.9	-	-
Инфляц, хувь	7.0	7.2-7.3	7.1	7.8
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн орлого /их наяд төг./ (ДНБ-д эзлэх хувь)	34.8 (30.4%)	29.8-33.6 (26.8%-29.8%)	- (30.8%) ²	- (32.1%)
МУНТ-ийн зарлага /их наяд төг./ (ДНБ-д эзлэх хувь)	36.5 (31.9%)	32.1-35.9 (28.9%-31.8%)	- (33.4%)	- (31.6%)
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн тэнцэл /их наяд төг./ (ДНБ-д эзлэх хувь)	-1.7 (-1.5%)	[-2.2 -2.3] (-2%)	- (-2.6%)	- (0.5%)
Засгийн газрын өр /их наяд төг./ (ДНБ-д эзлэх хувь)	57.1 (50%)	47.75 (42.3%)	- (45.8%)	- (36.6%)

Эх сурвалж: ТТБЗ (2026)

1.5 Эдийн засгийн өсөлт, макро эдийн засгийн тогтвортой орчныг хангах чиглэлд онцгой анхаарах шаардлагатай байна. 2025 онд эдийн засгийн өсөлт 6.8 хувьтай гарсан ч өсөлт энэ онд хадгалагдах эсэх нь эргэлзээтэй байна. Энэхүү өсөлтийн

¹ Английн эдийн засагч Колин Кларк ДНБ-д эзлэх төсвийн зардал 25%-аас дээш гарсан үед төсөв баланстай байсан ч инфляцыг өдөөдөг болохыг 1945 онд судлан тогтоожээ. Монгол Улсад 1997 оноос эхлэн төсвийн зардал Кларкийн хязгаарыг тогтмол давсан байдалтай байна. Colin Clark, "Public Finance and Changes in the Value of Money", *The Economic Journal*, Vol. 55, No. 220 (December 1945), pp. 371-389.

² ОУВС төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувийг тооцжээ.

дийлэнхийг мал аж ахуйн салбар бий болгосон бөгөөд салбарын энэхүү нөлөөлөл энэ онд үргэлжлэхгүйгээс гадна сүүлийн жилүүдийн үйлчилгээний салбар агшиж байгаа нь анхаарах асуудал юм. Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээрх үзүүлэлтүүд нь эдийн засгийн өсөлтийг хадгалж чадаагүй, макро эдийн засгийн тогтворгүй байдал үүссэн тохиолдолд төсвийн эрсдэл өндөр байгааг анхааруулж байна. Тухайлбал, дунд хугацаанд төсвийн зарлагын нэрлэсэн дүн 10.8 хувиар өсөж, 40,444.7 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа нь төсвийн орлого болон ДНБ-ийг мөн хэмжээнд өсгөөгүй тохиолдолд төсвийн тэнцэл алдагдах бодит эрсдэлийг харуулж байна.

1.6 Хос алдагдлын мөчлөг дунд хугацаанд хадгалагдах эрсдэлтэй хэвээр байна. 2023 онд Монгол Улс анх удаа төлбөрийн болон төсвийн тэнцлийн хувьд ашигтай гарсан нь эдийн засгийн хувьд эерэг үзүүлэлт болсон. Энэ нь удаан хадгалагдаж чадаагүй бөгөөд 2024, 2025 онд тэнцлийн хос алдагдалтай гарсан. Монголбанкны судлаачдын 2026 онд хэвлүүлсэн судалгаагаар төсвийн урсгал зардал, ДНБ-ий харьцаа 1 хувиар өсөхөд бодит импортын өсөлтийг 0.2-0.4 хувиар нэмэгдүүлдэг болох нь тогтоогджээ³. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, төлбөрийн тэнцлийн мэдээллээс харахад төсөв, төлбөрийн тэнцэл нь 2026 онд алдагдалтай гарахаар байгаа бөгөөд 2027-2028 онд ч энэ байдал давтагдах эрсдэлтэй байгаа нь төсөв, урсгал тэнцлийн хос алдагдлын мөчлөгт эдийн засгийг оруулж болзошгүй юм. Энэ нь төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд сөргөөр нөлөөлж эдийн засгийн дархлааг сулруулах үр дагавартай гэдгийг дахин сануулж байна.

Хоёр. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх

2.1 Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2027 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 10,264.2 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 127.4 ам.доллар байхаар төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.

2.2 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2027-2029 онуудад ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.

2.3 Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2027-2029 онуудад хуульд заасан хязгаарт буюу 50 хувь, 50 хувь, 45 хувь байхаар тооцоолжээ.

2.4 Тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-т

³ Б. Хулан, Д. Мядаг (2026), Төсвийн зардлын импортод үзүүлэх нөлөө, *Монголбанкны Судалгааны Ажлын Товхимол*, Дугаар 20: 188-210.

“2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2027-2029 онд ДНБ-ий -1.5, -1.0, -0.5 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.


2.5 Олон нийтийн хэлэлцүүлэг. Төсвийн тухай хуулийн 28^{1.4}-т “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон нийтийн хэлэлцүүлгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар зохион байгуулна” гэсэн заалтын дагуу хэлэлцүүлэг явуулсан үр дүнг төслийн танилцуулгад хавсралтаар тусгасан нь хуулийн заалтыг хэрэгжилтийг хангасан гэж үзэх үндэслэл болж байна.

Гурав. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар

3.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дахь хэсэгт оруулахаар санал болгож буй өөрчлөлт нь төсвийн тодотгол даган хүрээ нь өөрчлөгддөг өмнөх жишгийг үргэлжлүүлэх боломжийг нээх, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулахаар байна. Өнгөрсөн жилүүдэд төсвийн тодотгол хэмээх арга хэрэгслийг өндөр давтамжтай, тухайн жилийн төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэлбэрээр хэрэглэж ирсэн буруу жишгээс үүдэн төсөв, тодотгол хоёрт нэгэн ижил шаардлага тавих нөхцөл бүрдсэн бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дахь хэсэг нь Төсвийн тухай хуулийн 8.1.4 болон 8.4.5 заалтуудын хамтаар нэгэн ижил тавигдах шаардлагын нэг юм. Тус заалтад өөрчлөлт оруулан "түүний нэмэлт, өөрчлөлтийг", "Төсвийн тодотголын" гэснийг хассанаар төсөвт тавигддаг “хүрээг баталснаас багадаа 3 сарын дараа төсөв батлагддаг” жишиг төсвийн тодотгол дээр мөрдөгдөхгүй нөхцөл үүснэ. Улмаар өмнөх жилүүдийн жишгээр хүрээ нь төсвөө даган өөрчлөгдөх, төсвийн төлөвлөлтийг сайтар хийх замаар шаардлагагүй тодотголыг бууруулах чиглэлд хийгдэж буй алхмаасаа ухралт хийхэд хүргэх болно.

Өмнөх жилүүдэд төсвийн тодотголыг олон удаа хийсэн бөгөөд үүний үр дүнд төсвийн зарлага, алдагдал нэмэгдэж байсан боловч хөрөнгийн зарлагын өсөлт багатай байна.

Зураг 4. Төсвийн тодотголоор бий болсон орлого, зарлага, төсвийн алдагдлын хэмжээ /2011-2025 он/



2011 оноос хойш хийгдсэн төсвийн тодотголын үр дүнд төсвийн орлогыг 3.2 их наяд төгрөгөөр бууруулж, зарлагыг 7.5 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 10.6 их наяд төгрөгөөр өсгөж байсан байна. Харин төсвийн хөрөнгө оруулалтын зардал 403.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн тодотголоор бий болж байгаа зарлагын өсөлт урсгал зардалд чиглэж байгааг харуулж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-т "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл" гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг" хэмээн заасан бөгөөд энэхүү бодлогын баримт бичгийн төсвийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дахь хэсэг үйлчилдэг. Хуулийн энэхүү өөрчлөлт нь ДХТХМ-ийг өөрчилж түүнийг дагуулан төсвийн тодотгол хийх боломжийг нээж байгаа бөгөөд энэ асуудлын хувьд төсвийн тогтолцоо 2023 оны эрх зүйн шинэчлэлээс өмнөх байдал руу ухрахад хүргэж байна. Иймээс энэ хуулийн өөрчлөлтийг хийхдээ төсвийн тодотголоос бий болох үр дагавар, төсвийн тогтвортой байдал, улсын өр, төсвийн эрсдэл зэргийг харгалзан ДХТХМ-ийн ач холбогдлыг бууруулахгүй байх нөхцөлийг хангах нь зүйтэй.

3.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15.2.1 дэх заалтад оруулахаар санал болгож буй өөрчлөлт нь төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Тус хуульд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан өөрчлөлтийн төсвийн орлого дээрх шууд нөлөө нь -2,515 их наяд төгрөгөөс -1,204 их наяд төгрөг байхаар ТТБЗ тооцоолсон. Энэ нь дотоодын НӨАТ-ын орлогын 50-90 хувьтай тэнцэх дүн бөгөөд тус заалт 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнээр улсын төсвийн орлого мөн хэмжээгээр буурах, дотоодын НӨАТ-аас эдийн засагт үзүүлэх татварын сөрөг нөлөө (алдагдсан боломж), татвар хураахтай холбоотой зардал нь хэвээрээ хэр нь орлого бүрдүүлэлт нь эрс буурсан, үр ашиггүй татварын тогтолцоог үүсгэхээр байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 2020-2024 онд 26.2 хувь байсан бол нэрлэсэн ДНБ-ий өсөлт 17 хувь байжээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020-2024 оны урсгал зардлын өсөлт, түүний задаргаа, нэгж хувиар

Утга	2020	2021	2022	2023	2024
Урсгал зардлын өсөлт, хувиар	31.60	18.24	11.13	20.11	31.47
Цалин, хөлсний нөлөө	4.76	-1.08	-6.76	4.65	18.01
Бараа, үйлчилгээний бусад зардлын нөлөө	5.58	-0.30	-0.24	4.34	6.17
Зээлийн үйлчилгээний төлбөрийн нөлөө	0.95	-0.96	-0.30	2.48	0.14
Татаасны нөлөө	0.93	0.73	0.65	0.30	1.90
Урсгал шилжүүлгийн нөлөө	19.39	19.85	17.78	8.35	5.26

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Энэ тренд цааш үргэлжилбэл гурван жилийн дотор буюу 2028 онд урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 30 хувиас хэтрэх буюу төсвийн тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэх талаар ТТБЗ өмнө нь анхааруулсан⁴. Ийнхүү зарлагын өсөлтийг хязгаарлаж чадаагүй тохиолдолд эдийн засгийн цочрол, хямралын үед орлого бүрдүүлэлт сулрах эрсдэлтэйг харгалзан төсвийн орлогын найдвартай байдлыг хадгалах нь төсөв, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай хүчин зүйл болно.

Дөрөв. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

4.1 Төсвийн нийт зарлагын болон урсгал зардлын өсөлтийг хязгаарлах шаардлагатай байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь хуулийн тусгай шаардлагуудыг хангаж байгаа, макро эдийн засгийн таамаглалын хувьд олон улсын байгууллага, ТТБЗ-ийн таамаглалтай харьцангуй нийцтэй болсон, төрийн оролцоог бууруулах бодлогын зөв чиглэлийг баримталж буй боловч төсвийн зарлагын өндөр түвшин, урсгал зардлын өсөлт зэрэг нь төсвийн бодлогын хувьд анхаарах асуудал хэвээр байна. Иймд төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай юм.

4.2 Макро эдийн засгийн хувьд тодорхой эрсдэлүүдийг анхаарах хэрэгтэй. Макро эдийн засгийн өсөлт, нөлөөлөгч хүчин зүйлс тогтворгүй байгаа нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг бууруулахаар тодорхойлсон ч төсвийн зарлага төдийгүй гадаад эрсдэл өндөр байгаа нь инфляцын эрсдэлийг нэмэгдүүлэх, 2024, 2025 онд хос алдагдалтай гарсан, төсвийн урсгал зардал өссөн зэрэг нь дунд хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдалд дарамт учруулж болзошгүй байгааг анхаарах нь зүйтэй.

4.3 Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн нөхцөл байдлыг үл харгалзан өндөр хэвээр байна. Хуулийн төсөлд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 2027 онд 127.4 ам.доллар байхаар, харин зах зээлийн үнийг 68 ам.доллар байхаар тооцжээ. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а-д заасны дагуу "... ОУВС-гаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн

⁴ Урсгал зардлын жилийн өсөлтийг g , ДНБ-ийн жилийн өсөлтийг u гэвэл (Урсгал зардал/ДНБ) харьцааны өсөлт $r = \frac{g+1}{u+1} - 1 = 0.07$ болох ба өнөөдрийн байдлаар энэ харьцаа 0.25-0.27 байна гэвэл $0.25(1+r)^t = 0.3$ тэгшитгэлээс $t = 2.6$ жил.

мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох” мөн хуулийн 11.1.3.б-д заасны дагуу “... гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийн тооцоонд алтны тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах жилүүдийн дундаж үнийг тусгахдаа эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас гаргасан статистикт тусгасан үнийн дунджаар тооцох” хуулийн зохицуулалттай байгаа нь зарим жилүүдэд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ бодит үнээс хэт ялгаатай тогтох нөхцөлийг бүрдүүлж байна.

4.4 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-2025 оны хооронд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 22 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулиудын хоорондын уялдаа, нэгдмэл байдал болон зохицуулах чадварт нь сөргөөр нөлөөлж, төсвөө хүрээ нь дагадаг, тодотгол хийн төсвийн орлого, зарлага буурсан үед ч хүрээ нь хөндөгддөг нөхцөлд хүрсэн байна. Иймээс эдгээр хуулиудын нийцлийг эргэн харж тодорхой өөрчлөлт оруулах, дараах үзүүлэлтийг ДХТХМ-д тусгаж байх нь зүйтэй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ордоггүй, төсвийн төлөвлөлт болон тусгай шаардлагуудад шууд хамааралтай үзүүлэлтүүд

ДХТХМ-д багтаагүй үзүүлэлтүүд	ДХТХМ-д багтаах үндэслэл
Нэрлэсэн ДНБ	Төсвийн тусгай шаардлагууд нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгдэн хуульчлагдсан.
МУНТ-ийн урсгал зардал	Төсвийн тусгай шаардлагад туссан.
МУНТ-ийн орлого	Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагддаг.
Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ	Төсвийн тусгай шаардлага болох тэнцвэржүүлсэн орлого болон тэнцвэржүүлсэн тэнцлийг тооцоход ашиглагддаг.

4.5 Дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хангалттай тусгаагүй хэвээр байна. Дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.6 дахь хэсэг “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг энэ хуулийн 16¹.5.1-д⁵ заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэсэн заалтыг баримтлах эсэх нь тодорхойгүй, нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

⁵ 16¹.5.1 дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах.